



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/165

Баян-Овоо

**Эзэмшил газрын хэмжээ, хаягийг
өөрчлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21.1.57 дахь заалт, Монгол улсын Хаягжуулалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах тухай” журам, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21.1.57-д тусгагдсан “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх”, багаж технологийн нарийвчлал хэмжилтийн зөрүү, Хаягжуулалтын тухай хуулийн дагуу худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж байгаа газрын хэмжээг өөрчлөн хавсралтаар эзэмшүүлсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж гэрчилгээ олгохыг Газрын даамал (Б.Урансайхан)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/58 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

4. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Гэрэлмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХ-ОД